



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2018 оны 4 дүгээр сар

Танилцсан: Н.Баяртсайхан
Хянасан: Д.Ган-Очир
Б.Батсүрэн
Боловсруулсан: Мөнгөний статистикийн баг

Улаанбаатар
2018



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

**Нийт мөнгөний нийлүүлэлт
16.2 их наяд ₮ байна**



Нийт мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 166.2 тэрбум ₮ (1%-өөр өсөв)



M2 мөнгөний жилийн өсөлт 30.3 хувьд хүрсэн нь өмнөх сарынхаас бага зэрэг (0.9 нэгжээр) буурсан байна. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 55 хувийг төгрөгийн хадгаламж, 15 хувийг валютын хадгаламж, 14 хувийг төгрөгийн харилцах, 12 хувийг валютын харилцах бүрдүүлжээ.

Мөнгөний нийлүүлэлтийн валютын хадгаламжаас бусад бүрэлдэхүүн хэсгүүд тайлант сард өсчээ. Төгрөгийн хадгаламжийн хувьд иргэдийн хадгаламж 141.7 тэрбум төгрөгөөр өссөн бол байгууллагынх 46.7 тэрбум төгрөгөөр буурав (Хөгжлийн банкыг хасч тооцвол 2 тэрбум төгрөгөөр өсөв).

Нийт хадгаламжийн 83 хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлж 9.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 22 хувиар өсчээ. Иргэдийн төгрөгт итгэх итгэл сэргэж төгрөгийн хадгаламжийн хувь өсч байгаа нь хадгаламжийн долларжилт жилийн өмнөхөөс 6 нэгж хувиар буурч 19 хувьд хүрснээр харагдаж байна.

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр активын дүн 17.8 их наяд төгрөг, гадаад цэвэр актив -1.4 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Нийт дотоод активын 14.5 их наяд төгрөг нь эдийн засагт зээл хэлбэрээр байршиж байна.


Иргэдийн хадгаламжийн долларжилт буурч байна



Тайлант сард нөөц мөнгө 19 хувиар өсч 3.5 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 73.1 хувийг банкуудын харилцах, 18.6 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 8.3 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

БАНКУУДЫН ЗЭЭЛ


Нийт зээлийн үлдэгдэл 14.4 их наяд ₮-т хүрч, жилийн өсөлт 13.7%-т хүрэв




Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 19.6 хувиар өсч 7.13 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 8.2 хувиар өсч 7.12 их наяд төгрөгт тус тус хүрчээ.

Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 1,200.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 27.0 тэрбум төгрөгөөр буурсан нь чанаргүй зээл төлөгдсөн болон ангилал сайжирснаар тайлбарлагдаж байна.

Чанаргүй зээлийн дийлэнх боловсруулах, уул уурхай, худалдаа, барилга болон үл хөдлөх хөрөнгийн салбарт ногдож байна




Тайлант сард 1537.8 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1233.7 тэрбум ₮ эргэн төлөгдлөө



Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 123.8 тэрбум төгрөгөөр, төлөгдсөн зээл 126.4 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.3 нэгж хувиар буурч хугацаа хэтэрсэн зээлийнх 0.2 нэгж хувиар өсчээ. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 84.3 хувийг, чанаргүй зээлийн 81.0 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна.

Чанаргүй зээл нийт зээлийн 8.4%, Хугацаа хэтэрсэн зээл 6.8% байна




Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 175.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс боловсруулах салбарын зээл 60.9 тэрбум төгрөг, худалдааны салбарын зээл 40.8 тэрбум төгрөг, уул уурхайн салбарын зээл 35.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хувийн байгууллагад олгосон зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах үйлдвэр, барилгын салбарт ногдож байна



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн зээл эзэлж байна



Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 145.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Тодруулбал, цалин, тэтгэврийн зээл 67.4 тэрбум төгрөг, худалдааны салбарын зээл 35.9 тэрбум төгрөг, орон сууцны ипотекийн зээл 22.8 тэрбум төгрөг, хадгаламж барьцаалсан зээл 14.2 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Иргэдийн зээлийн 44.0 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2.7 их наяд төгрөгт хүрснээс 29.2 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 20.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 10.5 хувийг барилгын салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 6.1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 13.4 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 92,922-т хүрчээ. Нийт зээлийн 755.7 тэрбум төгрөг буюу 17.7 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол зээлээр худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 758.9 тэрбум төгрөг буюу 17.8 хувь нь орон нутагт ногдож байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувь нь хөтөлбөрийн зээл, 20.5 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.5 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Харин орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 78.3 хувь нь хөтөлбөрийн зээл, 20.8 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.9 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.1 хувиар өсчээ



Нийт ипотекийн зээлийн 77.0 хувь нь хөтөлбөрийн зээл байна



Тайлант сард банкууд 664 зээлдэгчид 50.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 41.1 хувь нь хөтөлбөрийн, 48.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.8 хувь нь хэвийн, 2.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.9 хувь нь чанаргүй зээл байна.

Ипотекийн зээлийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл буурсан байна



Ипотекийн зээлийн хүү тогтвортой байна



¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.


Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 64.0 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 34.3 хувийг хөтөлбөрийн зээл, 1.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.6 хувь буюу 3.9 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Нийт ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 76.0 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.6 хувийг эзэмшиж байна.

Тайлант сард ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 92922 байгаагийн **64.1 %** нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой зээлдэгчид байна.

Ипотекийн зээлийн 82.2 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ




ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ


Тайлант сарын эцэс дэх Монголбанкнаас зарласан төгрөгийн ханш голлох валютуудын эсрэг чангарч ам.доллар болон канад долларын эсрэг бага зэрэг суларсан ч тайлант сарын турш төгрөгийн ханшийн хөдөлгөөн тогтвортой байв. Ам.долларын эсрэг тухайн сарын хамгийн өндөр ханш 2402.9 төгрөг байсан бол хамгийн бага нь 2390.8 төгрөг байв.

Харин БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 0.3 хувиар суларч 380.1 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 378.64 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 381.5 төгрөг байлаа. Харин сарын эцсийн ханш 379.4 төгрөг буюу өмнөх сараас 0.5 хувиар чангарсан байна.

Төгрөгийн ханш тогтворжиж байна



Сарын эцсийн төгрөгийн ханш юаны эсрэг чангарсан байна



ХҮҮ

Шинээр олгож буй төгрөгийн зээлийн хүүг 2015-2018 онуудаар харахад 20.6-18.7 хувийн хооронд хэлбэлзэж байна. Зээлийн хүү 2017 оны 10 дугаар сараас эхлэн аажмаар буурах хандлагатай байгаа бөгөөд 4 дүгээр сарын байдлаар төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 19.3 хувьтай, валютын зээлийн ЖДХ 10.2 хувьтай байлаа.

2018 оны 4 дүгээр сард нийт шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 54.8 хувийг иргэдийн зээл, 43.7 хувийг хувийн байгууллагын зээл, үлдсэн 2 хувийг санхүүгийн болон бусад байгууллагын зээл эзэлж байна. Иргэдэд шинээр олгож буй зээлийн ЖДХ тасралтгүй буурч тайлант хугацааны эцсийн байдлаар 19.7 хувьд хүрчээ. Валютын зээлийн ЖДХ 4 дүгээр сарын байдлаар өмнөх сараас 1.8 нэгж хувиар буурч 13.0 хувь боллоо.

Иргэдэд олгож буй зээлийн хүү сүүлийн 6 сарын дунджаар 20 хувь байна




Бизнесийн зээлийн хүү 2018 он гарснаас хойш 18 хувь орчимд байна




2018 оны 4 дүгээр сарын байдлаар иргэд болон хувийн байгууллагын зээл нийт зээлийн үлдэгдлийн 49.6 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хувийн байгууллагад шинээр олгож буй төгрөгийн зээл 2018 оны 4 дүгээр сарын байдлаар 18.5 хувь, валютын зээл 10.0 хувьтай байна.

Иргэдийн хэрэглээний зээлийн ЖДХ 19.9 хувь байна



Иргэдийн хадгаламжийн хүү 2018 он гарснаас хойш тогтвортой байна




2018 оны 4 дүгээр сарын байдлаар төгрөгөөр олгосон зээлийн 44.9 хувийг


Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү 2013 оны 8 дугаар сараас эхлэн өсч

ХАВСРАЛТ 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Зураг 1.1. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Зураг 1.2. M2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц



Зураг 1.3. Нөөц мөнгөний бүтэц




Зураг 1.4. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив




ХАВСРАЛТ 2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн (тэрбум ₮)




Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь, салбараар



Зураг 2.9. Орон нутгийн зээлийн үлдэгдэл болон чанаргүй зээл




Зураг 2.10. Олгосон, төлөгдсөн зээл, зээлдэгчдийн тоо




ХАВСРАЛТ 3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Ипотекийн зээлийн үлдэгдэл аймгуудаар



Зураг 3.3. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.4. Тайлант сард шинээр олгосон зээл




Зураг 3.5. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.6. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.7. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Зураг 3.8. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.9. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.10. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

